

**“УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: НЗДҮАХ-Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүлж иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.							
1	Арга хэмжээ:1.1. НЗДҮАХ-1.2.6, НХТЖҮЧ-9.2.2 Толгойт дэд төвийг орон сууцжуулах төслийг эхлүүлнэ.	-	Хэрэгжүүлэх төслийн тоо	-	100%	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар “Гэр хорооллыг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай” захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэхийг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д даалгасан бөгөөд тус төслийн хүрээнд ажлын техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах ажлын төсвийн саналыг 4.2 тэрбум төгрөгөөр боловсруулан 2026 оны төсөвт тусгуулахаар НИТХ-аар хэлэлцүүлж байна.	90%

2	Арга хэмжээ:1.2. НЗДҮАХ-1.2.13. НХТЖҮЧ-9.8.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах төслийг эхлүүлнэ.	-	Буулгасан барилга, эхлүүлсэн төслийн тоо	-	100%	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинэчлэн барилгажуулах 80 байршлаас 15 төсөл хэрэгжүүлэгч компани шалгарч /Баянгол дүүрэгт 3, Баянзүрх дүүрэгт 1, Сүхбаатар дүүрэгт 7, Хан-Уул 1, Чингэлтэй дүүрэгт 2, Сонгинохайрхан дүүрэгт 1/ тус тус байршлуудад төсөл хэрэгжиж байна. Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны СТ-4 байрны /Гартаам Агат ХХК/ 240 өрхийн барилгын угсралтын ажил 90 хувь, Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэрсгэрт байрлах 32 дугаар байрны /Грейт рөүд ХХК/ барилгын зоорийн давхрын цутгалт, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 22 дугаар байрны /Хан хөгшин стэйт ХХК/ барилгын суурийн цутгалт тус тус бүрэн хийгдсэн байна.	90%
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөн хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэхээр даалгасан, түүний нөлөөлөлд өртсөн эзэмшигч, өмчлөгч этгээдийг түр суурьшуулах орон сууцаар хангах, нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэж, нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, хот байгуулалт, барилгын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах.							
3	Арга хэмжээ:2.1. Хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэхээр даалгасан гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах	-	Дахин төлөвлөлтөд хамруулах гэр хорооллын өрхийн судалгаа	-	35	Толгойт дэд төвийн барилгажилтын зураг төсөл хийлгэх ажлын бэлтгэлийг хангаж, Нийслэлийн орон сууц бодлогын газрын орон сууцны төлөвлөлттэй танилцаж, Толгойт дэд төв орчмын байршлын болон нөлөөлөлд нэгж талбарын судалгааг хийсэн. Мөн тухайн байршилд хамрагдаж буй иргэдэд мэдээллийг өгч, санал санаачлагыг төлөвлөлтөд	100%

	үйл ажиллагааг хэрэгжүүлэх.					тусгахаар бэлтгэн, иргэдтэй уулзалтуудыг шат дараатай зохион байгуулж, барилгажуулах үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж ажиллаж байна. Мөн дэд төвийг орон сууцжуулах ажлын хүрээнд нийгмийн болон дэд бүтцийн барилга байгууламж, газар чөлөөлөлтийн талаарх эхний суурь судалгааны ажлын санал асуулгад Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны 293, 2 дугаар хорооны 283, 34 дүгээр хорооны 277, нийт 853 иргэн хамруулж, хороодын хэсгийн ахлагч нартай хамтран айл өрхүүдээр явж санал хүсэлтийг сонсож ажилласан. Мөн тус бүс нутагт амьдарч буй иргэдийн санал хүсэлтийг ажил хэрэг болгох зорилгоор хороодын ажлын албатай хамтран ЕБС-ийн сурагчдын дунд "Миний хот Толгойт" сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулаад байна.	
4	Арга хэмжээ: 2.2. Орон сууцжуулах үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэгч этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах, холбогдох гэрээ байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих.	-	Сонгон шалгаруулалтын үр дүн хувиар	-		Нийслэлийн засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/721 дүгээр "Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааны удирдамжийг шинэчлэн батлах тухай" захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо Нийслэлийн засаг даргын 8 захирамжаар шилжиж ирсэн "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны барилгыг буулган шинээр барих" сонгон шалгаруулалтын байршил дээр сонгон шалгаруулалтын материал	90%

						бэлтгэн хуралдаж, гарсан шийдвэрийн дагуу нийт 14 байршилд сонгон шалгаруулалт явуулж Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-ийн захирлын батламж гардуулсан. Сонгон шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй Үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсныг батламжилсан тушаал гарсны дараа Хариуцлагын гэрээ, "Гурван талт" гэрээний нөхцөлийг ханган ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авч төсөлд шалгарсан 14 аж ахуйн нэгжид хүргүүлэн 4 аж ахуйн нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулж бусад аж ахуйн нэгжид төслийг хүргүүлэн хамтран ажиллаж, Журмын 4.8-д заасан шалгарсан гэрээ байгуулах эрх бүхий хуулийн этгээд нь тухайн орон сууцны барилгын үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчидтэй хоёр талт гэрээ байгуулж, Хоёр талт гэрээ нь гурван талд гэрээний хавсралт баримтад заагдсан 4.11 дэх заалтыг тусгасан байгуулахаар хамтран ажиллах гэрээ, хариуцлагын гэрээг төлөвлөн хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
5	Арга хэмжээ:2.3. Орон сууцжуулах үйл ажиллагааны хүрээнд холбогдох үйл ажиллагааны зардал, хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах.	-	Мөнгөн хөрөнгө болон орлого төвлөрүүлэх	-	100%	Нийслэлийн орон сууцны корпорациас 2025 оны 04 дүгээр сард Түр суурьшуулах орон сууцыг хүлээн авахад их хэмжээний хуримтлагдсан авлагатай ирсэн. Уг авлагыг барагдуулахаар Гэрээ эрхзүйн хэлтэстэй хамтран ажиллаж 47 орчим хувийг барагдуулсан. 2025 оны 11	100%

						дүгээр сараас 12 дугаар сар хүртэл 1 сарын хугацаатай Гэрээ эрхзүйн хэлтэстэй хамтран ажиллах А/62 тоот тушаалын дагуу ажлын хэсэг байгуулан орлого бүрдүүлэлтийн ажилтнууд түр суурьшуулахын Баянхошуу, Сэлбэ, 813, 814-р байранд амьдарч буй өндөр төлбөртэй айл өрхийн авлага, өрийг барагдуулах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Нийт өндөр өр төлбөртэй 57 айлаас 26 айлын өр төлбөрийг барагдуулан ажилласан. Хуримтлагдсан өр төлбөр барагдуулалт 45% байна. Нийт борлуулалтын орлого 90%-тай байна.	
6	Арга хэмжээ:2.4. Орон сууцжуулах үйл ажиллагааны хүрээнд төсөл, төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцож гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, гэрээний биелэлтийг хамтран дүгнэх.	-	Гэрээний хэрэгжилтийн хувь	-	100%	Түр суурьшуулах 813, 814 дүгээр байр, Сэлбэ 50, Баянхошуу 50 байрны оршин суугч нартай гэрээ байгуулан ажиллаж гэрээний хэрэгжилт 80,9 хувьтай байна. Түр суурьшуулах орон сууцанд хамрагдсан 50 оршин суугч иргэдтэй түр оршин суух түрээсийн гэрээг 2025 онд шинээр байгуулах зорилгоор 186 мэдэгдэх хуудсыг тарааж, 103 иргэдтэй биечлэн уулзаж гэрээний биелэлтийг дүгнэсэн байна. 2025 оны 04 дүгээр сараас эхлэн давхардсан тоогоор 407 түрээсийн айл өрхтэй гэрээ байгуулан ажилласан.	90%

7	Арга хэмжээ:2.5. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд хот байгуулалтын холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагаар батлуулах.	-	Батлуулсан баримт бичгийн тоо, хэрэгжилт хувиар	-	100%	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар бүхий захирамжаар Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхийг олгосоны дагуу "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл" /GADIP/-ийн нэгжээс холбогдох мэдээлэл, материалыг хүлээж авч хамтран ажиллаж байна. Толгойт дэд төв орчмын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд орон сууцжуулах үйл ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд төслийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах ажил барилгажилтын төсөл боловсруулах ажлын төсвийн саналыг Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан. Хот байгуулалтын баримт бичгийн хүрээнд Барилгажилтын зураг төсөл хийгдсэний дараа түүний дагуу барилга тус бүрт Архитектур төлөвлөлтийн даалгавар болон загвар зургийг батлуулах боломжтой юм. Төслийн байршил дахь 1922 өрхөд дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе шат, холбоотой хууль	90%
---	--	---	---	---	------	---	-----

						тогтоомж, журам, баримт бичгийн талаарх мэдээллийг хүргэсэн ба тухай байршил дахь иргэдийн 45.6 хувиас анхны суурь судалгааг авсан.	
8	Арга хэмжээ:2.6. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан барилгажилтын төслийн дагуу орон сууцжуулах үйл ажиллагаанд захиалагчийн хяналт тавих.	-	Төслийн хэрэгжилтийн хувиар	-	100%	“Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д Нийслэлийн Засаг даргын 9 захирамжаар Сонгинохайрхан дүүрэгт 11, Чингэлтэй дүүрэгт 2, Сүхбаатар дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 1, Баянгол дүүрэгт 16 байршлын ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны байрыг буулган дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлэх эрх олгогдсон. “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д Нийслэлийн Засаг даргын 9 захирамжаар Сонгинохайрхан дүүрэгт 11, Чингэлтэй дүүрэгт 2, Сүхбаатар дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 1, Баянгол дүүрэгт 16 байршлын ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны байрыг буулган дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлэх эрх олгогдсон.	90%

						Мөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг даалгасан. Дахин төлөвлөлт зарлагдаж сонгон шалгарсан 15 аж ахуйн нэгжийн оршин суугч 1074 өрхтэй гэрээ байгуулахаас тайлангийн хуцгацаанд төсөл хэрэгжиж байгаа 5 компанийн байр захиалсан 204 өрхтэй 3 талт гэрээ байгуулсан байна.	
9	Арга хэмжээ:2.7. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан гэр хорооллыг орон сууцжуулах нэгж талбарыг сонгон батлуулах санал хүргүүлэх.	-	Саналын тоо, хэрэгжилтийн хувь	-	100%	Одоогоор 15 байршилд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг буулгаж дахин барилгажуулах зарыг өдрийн сонин, байгууллагын вэб сайтаар олон нийтэд зарлаж төсөл сонгон шалгаруулалтыг явуулаад байна.	90%
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хууль тогтоомж, Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж ажиллана.							
10	Арга хэмжээ:3.1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл					Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1 зорилтын 2 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 1	90%

	ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж дээд газарт тайлагнах.					зорилтын 3 арга хэмжээ 90 хувь, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 зорилтын 3 арга хэмжээ 90 хувийн биелэлттэй бөгөөд дээд газарт улирал бүр хугацаанд нь тайлагнасан.	
11	Арга хэмжээ:3.2. Засаг даргатай байгуулсан "Хариуцлагын гэрээ", байгууллагын үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг нэгтгэн хагас, бүтэн жилээр дээд газарт тайлагнах.	-	Хэрэгжилтийн хувиар	-	100%	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас "Улаанбаатар орон сууцжлуулалт" ХХК-ийн удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 01/109 тоот гэрээгээр байгуулсан. Байгууллагын үйл ажиллагааны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн батлуулж, төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 95%-ийн гүйцэтгэлтэй Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг 94.2%тай Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан.	95%
12	Арга хэмжээ:3.3. Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсуулж батлуулна,	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	Байгууллагын Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/42 тоот тушаалаар байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг ТУЗ болон НЗДТГ-аар батлуулж төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулан 3 чиг үүрэг, 17 зорилт, 34 арга хэмжээтэйгээр төлөвлөгөөг батлуулан ажилласан.	100%
13	Арга хэмжээ:3.4. Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	Манай байгууллага нь 2025 онд шинээр байгуулагдсан бөгөөд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийх, засаглалын тогтолцоог оновчтой	90%

	оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ.					болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэх, удирдлагын тогтолцоонд шинэчлэл өөрчлөлт хийх асуудлаар удирлагын түвшинд хэлэлцэн холбогдох дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	
14	Арга хэмжээ:3.5. MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. стандартын баталгаажуулалтыг эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	Зөвлөн туслах үйлчилгээний зардлыг байгууллагын 2026 оны төсөвт тусгах	MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлын бэлтгэл ажлыг ханган тус зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх зардлыг байгууллагын 2026 оны төсөвт тусгуулан ажилласан.	100%
15	Арга хэмжээ:3.6. Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Бэлтгэл ажил хангах	-		Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын А/21 дүгээр тушаалаар Дотоод хяналтын журам батлан, 12 заалт бүхий дотоод хяналтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 %-тай ханган ажилласан.	90%
16	Арга хэмжээ:3.7. Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Боловсруулсан мэдээллийн тоо	-	2	Тус арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, ГАДИП төслийн нэгж, Дүүргүүд, Хороодтой хамтран статистикийн мэдээллийг боловсруулан, холбогдох газарт тайлагнан ажиллаж байна.	100%
17	Арга хэмжээ:3.8. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байх	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" 311 дүгээр тогтоолын	100%

	хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.					хэрэгжилтийг ханган байгууллагын 8 хэлтэс 1 албаны дотоод үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулан холбогдох зөвлөмж, мэдээллийг өгч ажиллаж байна.	
18	Арга хэмжээ:3.9. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, 2025 оны эдийн засгийн үзүүлэлтийг ханган үр ашгийг нэмэгдүүлнэ.	-	Эдийн засгийн үр ашгийн нэмэгдүүлж, хэмнэсэн мөнгөн хөрөнгийн дүн төгрөгөөр		100%	Байгууллагын санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан үйл ажиллагаанд доголдуулахгүйгээр санхүүгийн сахилга батыг сайжруулан зардлыг хэмнэн тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90%
19	Арга хэмжээ:3.10. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулж тайлагнах		Шилэн дансны хуулийн дагуу байршуулсан тоо	-	100%	Шилэн дансны дотоод аудит хийхэд ашиглалтын зардлуудыг оруулаагүйг нөхөн байршуулах зөвлөмжийн дагуу орлогын 25,943,26 мянган төгрөгний дансны хүүгийн орлого, 9 зарлагын 82,339,72 мянган төгрөгний зардлыг нөхөж оруулсан. 4-р улирлын байдлаар нийт 157 мэдээ байршуулахаас 135 мэдээг хугацаанд нь хоцорсон 5, мэдээлэлгүй 17 мэдээ байна.	90%
20	Арга хэмжээ:3.11. Албан хэрэг хөтлөлтийн систем erp.ulaanbaatar.mn системийн edoc цэсэд бүртгэгдсэн албан бичгийн шийдвэрлэлт,	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь, тоо	-	100%	Албан хэрэг хөтлөлтийн систем Edoc программд бүртгэгдсэн холбогдох албан бичиг, өргөдлийг журмын дагуу хөтөлж хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллаж байна.	

	зөрчлийн байдалд хяналт тавьж ажиллах, баримт бичгийн эргэлтийн мэдээ, өргөдөл гомдлын тайланг сар тутамд гаргаж удирдлагуудад танилцуулах.					Тайлант хугацаанд явуулсан бичгийн шийдвэрлэлт нийт 466 бичиг байгаагаас - Хариугүй бичиг 441, хариутай бичиг 25 байгаагаас шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 100%-тай байна. Мөн ирсэн бичгийн шийдвэрлэлт нийт 390 бичгээс - Хариутай 35, хариугүй 355, судлагдаж байгаа 8 бичгийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 98,48%, хариугүй бичгийн хаалтын хувь 99,86%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 98,76%-тай шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.76 хоногтой байна.	100%
21	Арга хэмжээ:3.12. “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж,	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	-	100%	MNS6395:2022 стандартын дагуу байгууллагын хэвлэмэл хуудсыг захиалж албан хэрэгцээнд ашиглаж байна. Албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж, явсан бичгийн стандартыг ханган албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.	100%

	албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлнэ.						
22	Арга хэмжээ:3.13. "Албан хаагчдыг хөгжүүлэх, сургах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хамрагдсан албан хаагчид	-	Албан хаагчийг тэтгэлэгт хамруулсан тоо.	Нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тайлант хугацаанд байгууллага нь албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэдний нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 7 албан хаагчид нийт 3,100,000 төгрөгийн санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн байна.	100%
23	Арга хэмжээ:3.14. Ажилтан, албан хаагчдыг богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.	-	Сургалтад хамрагдах албан хаагчдын тоо	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо зарцуулсан төсөв.	Байгууллагын ажилтан, албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлж, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан 25 заалттай "Сургалтын төлөвлөгөө"-ний дагуу Баримт бичгийн стандарт 2, Төсөвчний анхан шатны мэргэшүүлэх 2, Цахилгаанчны анхан шатны сертификат олгох 2, Үндэсний монгол бичгийн дүрэм эзэмших сургалтад 16, Хиймэл оюун ухаан (AI) 3, ХАБЭА-ийн анхан болон дунд шат3, ХАСХОМ сургалтад 2, Судалгааны ерөнхий арга зүйн "Судлаач" сургалтад 2, Засгийн газрын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт (АЗ)-ын анхан шатны сургалтад 2, Төсөвчний анхан шатны сургалтад 2, АТГ-аас зохион байгуулсан сургалт нийт албан хаагч нар бүгд хамрагдсан, Өндөр барилгын олон улсын туршлага ба шийдэл сургалтад 3, "Төрийн болон орон нутгийн өмчийн	100%

						нэгдсэн цахим систем"-ийн сургалт 2, Татварын мэргэшсэн зөвлөхийн шалгалтад бэлтгэх сургалт 1, HUNNU CITY Архитектор үзэсгэлэнт худалдаа сургалт 1, зэрэг нийт 15 төрлийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 44 албан хаагчийг хамруулан ажилласан.	
24	Арга хэмжээ:3.15. Ажилтан, албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Дотоод эх үүсвэр	Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан тоо, хувь	-	100%	Байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийн байдлыг хянах, өвчлөлийн эрт илрүүлэг хийх зорилгоор "Нийслэлийн Өргөө амаржих газар"-тай хамтран нийт эмэгтэй 38, эрэгтэй 42 албан хаагчийг хамруулсан урьдчилан сэргийлэх үзлэгийг 2025 оны 09 дүгээр сарын 26, 29, 30-ны өдрүүдэд болон 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулан ажилласан.	100%
25	Арга хэмжээ:3.16. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100%	Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ны авилгын эсрэг үйл ажиллагааны 2025 онд хэрэгжүүлэх 3 зорилт 22 бүлэгт төлөвлөгөөг гарган байгууллагын даргаар харъяа, хэлтэс, алба, ажилтан, албан хаагчдад хүргэсэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	95%
26	Арга хэмжээ:3.17. "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,	-	Хэрэгжилтийн хувь	-	100%	Байгууллагын ажилтан албан хаагч нарт Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-	80%

	соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.					2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн алба хаагчийн ёс зүйг эрхэмлэн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн иргэнтэй зөв боловсон харьцах, байгууллагын дотоод журмыг дагаж мөрдөхөд мэргэжил арга зүйгээр ханган ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
27	Арга хэмжээ:3.18. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах		Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг нураан дахин барилгажуулах-Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны хэлтэс;			Хотын хөгжлийн индексийг тооцох үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 индексийн дагуу Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны нийт 33 байршил дахь барилгыг буулган дахин барилгажуулах ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	90%
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.							
28	Арга хэмжээ:4.1. Иргэд, хуулийн этгээдээс байгууллагын албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягталж судлан, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж	-	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	-	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас удирдлага болон албан хаагчдад тайлант хугацаанд edoc програмд бүртгэгдсэн нийт 33 өргөдөл үүнээс 32 нь 100% хууль зүйн үндэслэлтэй, гүйцэд эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 1 өргөдөл судлагдаж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж	95%

	хариу өгөх ажлыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах.					хугацаа 9 хоног 12 цаг 25 минут 95%- тай байна.	
29	Арга хэмжээ:4.2. Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, аюулгүй байдлыг ханган, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулах.	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	-	100%	“Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн цахим хуудасны үндсэн цэс, бүтэц, байрших мэдээ, мэдээллийн булан зэргийг боловсруулан батлуулав. Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК- ийн веб сайтыг төрийн байгууллагын веб сайтын шаардлага, стандартад нийцүүлэн хөгжүүлэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх байгууллага, гэрээг ажилтныг судалж танилцуулав. 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр тус ажлыг гүйцэтгэх ажилтантай ажил гүйцэтгэх гэрээ боловсруулан батлуулав. Веб сайтыг тогтмол хөгжүүлж, нийтлэх мэдээ, мэдээллийн төрөлжүүлэх, шинэчлэх ажил явагдаж байна. 1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийг баримтлан ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нийт 27 зарыг байгууллагын албан веб хуудаст байршуулахын зэрэгцээ сонгон шалгаруулалтын журмын	100%

						дагуу өдөр тутмын 3 сонинд (Өдрийн сонин, Зууны мэдээ сонин, Өнөөдөр сонин) байршуулж ажилласан. Гадны зочид төлөөлөгчдийн уулзалт, аж ахуй нэгжүүдэд батламж гардуулах үйл ажиллагаа зэргийг 10 (Ulaanbaatar.mn, Erennews.mn, Chig.mn, Zugii.mn, Ergelt.mn, Eguur.mn, Sonin.mn, Murch.mn, Humanz.mn, Vip76.mn) сайтад тогтмол нийлүүлдэг.	
30	Арга хэмжээ:4.3. Иргэд, олон нийтэд байгууллагын чиг үүрэг, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг танилцуулж мэдээ мэдээллээр хангах	-	Иргэд бодит мэдээллээр хангагдсан байх	-	100%	“Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөлтэй холбоотой хурал, гурван талт уулзалт, байршлуудын дахин төлөвлөлтийн талаарх фото, видео мэдээ бэлтгэн байгууллагын албан цахим хуудсуудад тогтмол нийтэлж байна.	100%
Зорилт 5. Бусад чиг үүргийн хүрээнд							
31	Арга хэмжээ:5.1 Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан бүх нийтээр мод тарих, цаашид арилан хамгаалах ажлыг зохион байгуулах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан бүх нийтээр мод тарих, цаашид арчлан хамгаалах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах Инчоны цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулан нийт 60 хуайсны суулгац тарьж мөн 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 23-р хорооны Олон булагтайн цэцэрлэгт	100%

						хүрээлэнд 50 ширхэг гацуур мод тарьж бүх хэлтэс, албадын ажилчдыг хамруулан ажилласан.	
32	Арга хэмжээ:5.2. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд биеийн тамир, соёл урлагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах, дээд газар болон байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд хамруулан ажиллах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	5	“Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн ажилтан, алба хаагчид 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээнд нэгдэж, Хуримын ордны урд талаас Хүүхдийн ордны баруун талын уулзвар хүртэлх 500 м2 зам талбайг цэвэрлэн 515 кг хатуу хог хаягдлыг шуудайлан ачуулсан. -Улаанбаатар хотноо 10 дахь жилдээ зохион байгуулж буй уг марафонд байгууллагын нийт 33 албан хаагч 5 км-ийн замд гүйж амжилттай оролцсон. -2025.05.31-нд Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-иас зохион байгуулсан хүүхдийн баярын арга хэмжээнд 3 байршлийн түр суурьшуулах орон сууцнуудын 500 гаруй хүүхэд оролцож бэлэг авч, урлагийн үзүүлбэр үзэн үлгэрийн баатруудтай зураг татуулж сэтгэл дүүрэн нэгэн өдрийг хамтдаа өнгөрүүлсэн. - 2025 оны 6 дугаар сарын 28–30 – “Хүрээ Цам–Даншиг наадам 2025”-д оролцсон. - 2025 оны 9 дүгээр сарын 3–4 – Монгол Улсад орчин цагийн барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жил, Нийслэлийн орон сууцны корпораци	100%

						ХК-ийн 10 жилийн ойд зориулсан 6 төрөлт спортын наадамд баг хамт олноороо дэд байр эзэлсэн. - 2025 оны 9 дүгээр сарын 12-14 – 38 дахь удаагийн “BARILGA EXPO” олон улсын үзэсгэлэнд оролцсон. - Барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жилийн ойг тохиолдуулан “Хотын дахин төлөвлөлт, асуудал ба шийдэл” сэдэвт 3 үе шат бүхий багц ажлыг зохион байгуулан ажилласан байна.	
--	--	--	--	--	--	---	--

Хэрэгжилтийн дундаж хувь: %

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ГАЗРЫН
ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
ТОГТООЛ ШИЙДВЭР, ТӨЛӨВЛӨГӨӨ,
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Б.ПҮРЭВСҮРЭН

Б.БАЛЖИННЯМ

Б.УНДРАХ

УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ ХХК

“УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ хийхэд:

Хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээ/гүйцэтгэл		Нийт
Хяналтад арга хэмжээний тоо		32
1	Бүрэн хангалттай 85%-иас дээш гүйцэтгэлтэй	32
2	Хангалттай буюу 70-85%-ийн гүйцэтгэлтэй	-
3	Хангалтгүй буюу 70 %-иас доош гүйцэтгэлтэй	-
Хэрэгжилтийн дундаж хувь		95%

Тус бодлогын баримт бичгийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалын дагуу хийхэд хяналтад авсан 32 заалт Бүрэн хангалттай буюу 95%-тай хэрэгжсэн байна.

Хэрэгжилтийг холбогдох журмын дагуу үр дүнг тооцвол:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин-Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин-Суурь түвшин}} * 100\% = \frac{95\%-0}{100\%-0} * 100\% = 95\% \text{ болно.}$$

Манай байгууллага нь 2025 онд шинээр байгуулагдсан тул суурь түвшинг 0-ээр тооцов.

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт нь 5 зорилт 32 арга хэмжээний хүрээнд:

- 100%-тай хэрэгжсэн 15 арга хэмжээ
- 95%-тай хэрэгжсэн 2 арга хэмжээ
- 90%-тай хэрэгжсэн 15 арга хэмжээ тус тус байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж 95%-тай байна.


ТАНИЛЦСАН:

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ЗАХИРГААНЫ АХЛАХ, ДОТООД ХЯНАЛТ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН 

Т.ЭНХМАА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 дугаар сарын 03

Дугаар 18

Улаанбаатар хот

Захирлын дэргэдэх Зөвлөлийн хурлыг байгууллагын Хурлын зааланд 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 16:00 цагт эхэлж 16:36 минутад дуусав. Ирц 100 хувьтай.

Хуралд:

Захиргаа, санхүүгийн газрын дарга -Б.Пүрэвсүрэн

Захиргааны хэлтсийн дарга - Ж.Балжинням

Санхүүгийн хэлтсийн дарга -Г.Доржханд

Гэрээ эрх зүйн хэлтсийн дарга - Ж.Амгалан

Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн дарга- Д.Ундрахсүрэн

Барилгын инженер техникийн хэлтсийн дарга-П.Амгаланбаатар

АШХангахгүй орон сууцны хэлтсийн дарга-Б.Бат-Учрал

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга-Д.Отгонсүрэн

Орон сууц ашиглалтын албаны дарга -Т.Батдэлгэр

Захиргааны хэлтсийн ахлах мэргэжилтэн – Т.Энхмаа/саналын эрхгүй/ нар оролцов.

Хэлэлцэх асуудал 1: Байгууллагын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх.

СОНССОН НЬ:

Т.Энхмаа ЗХ-ийн ахлах мэргэжилтэн: Байгууллагын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж нэгдсэн үнэлгээний танилцуулгыг хэлэлцэн дээд газарт уламжлахаар өнөөдрийн хурлыг хийж байна. Та бүхэн танилцан саналаа хэлнэ үү.

/Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хяналт шинжилгээний танилцуулгын хамт гишүүдэд хэвлэмэлээр тарааж өгөв/

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Пүрэвсүрэн дарга: Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон Хяналт, шинжилгээний танилцуулгатай танилцахад төлөвлөгөөний биелэлтийн 7, 10, 15 дугаар арга хэмжээнүүдийн бичвэрт үг үсгийн бага зэрэг алдаа байгааг засварлах,

зэрэг жижиг засваруудыг хийх шаардлагатай байна. Хэлтсийн дарга нарт хэлэх санал байвал тодорхой хэлнэ үү.

Ж.Балжинням ЗХ-ийн дарга: Миний хувьд төлөвлөгөөний биелэлттэй танилцсан байгаа мөн ахлах мэргэжилтэн Т.Энхмаагийн гүйцэтгэсэн хяналт шинжилгээний танилцуулгаас харахад гүйцэтгэл бол 95%-тай бүрэн хангалттай үнэлэгдсэн байна. Үнэлгээтэй санал нийлж буй тул нэмэлт санал байхгүй болно.

Г.Доржханд СХ-ийн дарга: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон ХШ-ний танилцуулгатай танилцлаа. Надад мөн нэмэлт саналгүй байна. Хэлтсээс тайлан биелтийг холбогдох мэргэжилтэнд өгч нэгтгүүлсэн өөрийн биеэр хянасан байгаа.

Д.Отгонсүрэн ГХДТХ-ийн дарга: Манай хэлтсийн хувьд биелэлтийг хугацаанд нь гарган Б.Ундрах мэргэжилтэнд хүргүүлсэн. Эдгээр танилцуулгуудад нэмэлт саналгүй болно.

Б.Пүрэвсүрэн дарга: Хэлтсийн дарга нарт нэмэлт саналгүй бол Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон хяналт, шинжилгээний танилцуулгыг дээд газарт хугацаанд нь тайлагнахыг дэмжиж байна уу?

Гишүүд бүгд санал нэгтэйгээр дэмжив.

Ж.Балжинням ЗХ-ийн дарга: Ахлах мэргэжилтэн Т.Энхмаа тайлан биелэлтэд холбогдох засваруудыг хийж гүйцэтгэн бичиг хэргийн стандартыг хангуулан хэвлэж баталгаажуулан дээд газарт хүргүүлэх албан бичиг төлөвлөн хянуулаарай. Өөр саналгүй бол хурлыг өндөрлөө.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Байгууллагын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөөний биелэлт болон Гүйцэтгэх захирлын Хариуцлагын гэрээний хэрэгжилт мөн Хяналт шинжилгээний танилцуулгын хамт Нийслэлтийн Засаг даргын тамгын газарт албан бичгээр болон файл хэлбэрээр хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.БАЛЖИННЯМ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Т.ЭНХМАА